

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Нийлүүлэх хүлэмж нь Монгол Улсад мөрдөгдөж буй "Зуны нийлэг хальсан хүлэмж Техникийн ерөнхий шаардлага" MNS 6636:2016 стандартын шаардлагыг хангасан өргөн 4 метр, урт 8 метр хэмжээтэй нийт 32 мкв талбай бүхий иж бүрэн 1000 ширхэгээс доошгүй хүлэмж байна.

2. Тендерт оролцогч нь дараах материалыг тендерийн хамт заавал ирүүлнэ.

2.1 Санал болгож буй хүлэмжийн нуман нурууны ган хоолой, нийлэг хальс, усалгааны хоолой, шүүлтүүр, тэдгээрийн холбох, бэхлэх хэрэгслэл тус бүрийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг (техникийн үзүүлэлтүүдийг харуулсан үйлдвэрлэгчээс гаргасан хэвлэмэл танилцуулга, зураг) Монгол хэлээр албан ёсны мэргэжлийн хэллэгээр орчуулж, эх хувьтай хамт ирүүлнэ.

2.2 Санал болгож буй бараа /хүлэмжийн нуман нурууны ган хоолой, нийлэг хальс, усалгааны хоолой тус бүрт нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолтод заасны дагуу 1)Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын ISO 9001 чанарын шаардлагыг хангаж буй тухай гэрчилгээ, 2)тухайн үйлдвэрлэгч орны барааны гарал үүсэл эсвэл үйлдвэрийн бүртгэлийн гэрчилгээ, 3) тухайн бараа нь энэхүү тендерийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох тухайн улсын чанар, стандартын албан ёсны байгууллагын шалгалтын дүгнэлтийг тухайн улсын нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны хуулбарыг орчуулгын товчоогоор орчуулж хамт ирүүлнэ.

2.3 Санал болгож буй хүлэмж, усалгааны тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны тухай танилцуулгыг Монгол хэл дээр орчуулж эх хувьтай хамт ирүүлнэ.

2.4 Хүлэмжийг барих, угсрах зураг, технологи бүхий зааврыг мэргэжлийн хэллэгээр Монгол хэл дээр бэлтгэж ирүүлнэ.

2.5 Худалдааны гэрээг ирүүлэх бөгөөд уг гэрээг Монгол хэл дээр албан ёсны орчуулгын газраар орчуулж ирүүлэх, худалдааны гэрээний хугацаа хүчин төгөлдөр байх

2.6 Тендерт оролцогч нь үйлдвэрлэгч болон гэрээт борлуулагчийн зөвшөөрөл ирүүлнэ. (Үйлдвэрлэгч болон гэрээт борлуулагчийн зөвшөөрөл гэдэгт албан бичиг, хамтын ажиллагааны гэрээ, гэрээт борлуулагчийн гэрчилгээний аль нэг нь байж болно).

2.7 Барааны чанарын баталгаат хугацаа: 12 сар ба түүнээс дээш байх тухай мэдэгдэл ирүүлнэ.

2.8 Тухайн санал болгож буй хүлэмжийг 2024 онд үйлдвэрлэсэн байх



## *Шалгалт, туршилт*

- 1. Хүлэмжийг хүлээлгэн өгөх үед шалгаж хүлээн авна. Шалгах үед хүлэмжийн иж бүрдэл нь “Зуны нийлэг хальсан хүлэмж Техникийн ерөнхий шаардлага MNS 6636:2016” стандартын шаардлагыг хангаагүй, эвдрэл гэмтэлтэй тохиолдолд нийлүүлэгч өөрийн зардлаар ялгаж, зөрүү тоог хэмжээгээр акт үйлдэж, хохирлыг хүлэмж нийлүүлэх санал болгосон мөнгөн дүнгийн зөрүүгээр барагдуулна.**



## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

### Барааны нэр:

Нийлүүлэгдэх хүлэмж нь Монгол Улсад мөрдөгдөж буй "Зуны нийлэг хальсан хүлэмж Техникийн ерөнхий шаардлага" MNS 6636:2016 стандартын шаардлагыг хангасан өргөн 4 метр, урт 8 метр хэмжээтэй нийт 32 кв талбай бүхий иж бүрэн 1000 ширхэгээс доошгүй хүлэмж байна.

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	Санал болгож буй техникийн тодорхойлолт <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	Тайлбар <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
1.	<p>Барааны ерөнхий үзүүлэлтүүд  <b>1.1 Барааны нэр, модель</b>  <b>1.2 Гарал үүсэл</b>  <b>1.3 Үйлдвэрлэгчийн нэр, хаяг</b>  <b>Үйлдвэрлэсэн он, сар, өдөр:</b>                      2024 онд үйлдвэрлэсэн байна.</p>		
2.	<p><b>Төрөл:</b> Нийлэг хальсан бүрхүүлтэй, нуман оройтой, хавар-зун-намар ашиглагдах, хүнсний ногоо тариалах боломжтой хүлэмж байна.                      Өргөн нь 4 метр, урт нь 8 метр, өндөр нь 2,5 метрээс доошгүй байна.</p>		
3.	<p><b>Нийлэг хальсан бүрхүүл:</b>                      Нарны гэрэл сайн нэвтэрдэг, тунгалаг, хэт ягаан туяаны хамгаалалттай, дулаан барих чадвартай, усан дусал үүсгэдэггүй нийлэг хальс байна.                      -40-өөс +50 хэмд физик шинж чанараа алддаггүй, 0.10 мм-ээс дээш зузаантай, ашиглалтын хугацаа 2-оос доошгүй жил ашиглах боломжтой.                      Салхины даац 15кг/м<sup>2</sup>-аас багагүй байна.                      Бүрхүүл хучлаганд этилен винил ацетат нийлэг хальс (EVA),</p>		



	<p>полиолефин нийлэг хальс (PO), нягтшил багатай полиэтилен (LDPE, LLDPE) ашиглана.</p> <p>Заагдсан хэмжээтэй нуман нурууг бүрэн хучихад хүрэлцэхүйц хэмжээтэй байна.</p>		
4.	<p><b>Нуман нуруу /каркас/</b></p> <p>Зэвэрдэггүй цайрдсан гангаар хоолойгоор хийсэн байна. Нуман нуруу ган хоолойн голч 25,0-25,4 мм-ээс доошгүй, ган хоолойн зузаан 1,5 мм-ээс доошгүй, нуман нуруу ган хоолой хоорондын зай 1,0 м-ээс доошгүй, ган хоолойн тоо 3-аас доошгүй, хөндлөн бэхэлгээ ган хоолойн голч 25,4 мм-ээс доошгүй, хөндлөн бэхэлгээ ган хоолойн зузаан 1,2 мм-ээс доошгүй байна.</p> <p>Каркас нь хучлага болон бусад хийцийн материал, төхөөрөмжийг даахуйц бат бөх, даац нь 25 кг/м<sup>2</sup>-аас багагүй байвал зохино.</p> <p>Каркасны салхи тэсвэрлэх даац (25-27) м/сек-ээс багагүй байна.</p> <p>Цайрын хэмжээ 300г/м<sup>2</sup> аас доошгүй байна.</p>		
5.	<p><b>Усалгааны систем:</b> 32 м<sup>2</sup> буюу 8м-ийн урт, 4 м-ийн өргөнтэй талбайд 6 дуслын услалтын систем, ус шахах цахилгаан помп, усны механик бохирдол шүүх филтэртэй байна.</p> <p>Хуванцар материал нь (PE-политэтилен, PET/PETE-халуунд тэсвэртэй полимер нэгдэл, PP-полипропилен)-аар хийсэн хоолой байна.</p>		
6.	<p><b>Агааржуулагч:</b> Хүлэмжийн хажуу тал нь уртын дагуу (0,8-1,2) м-ээс ихгүй өргөнтэй агааржуулалтын нээлхийтэй байна. Нээлхийг нээж, хаах гар болон механик төхөөрөмжөөр тоногдсон байна.</p>		
7.	<p><b>Хаалга:</b> 32м<sup>2</sup> талбай хүлэмжний хаалганы өргөн нь 0,9-1,0 м, өндөр нь 1,9 м-ээс доошгүй байна.</p> <p>Хаалга хүлэмжийн нүүрэн талын хананд дүүжин байдлаар угсарч зориулалтын зам дээр дугуйгаар 2 тийш гүйж нээгдэж, хаагдахаар хийгдсэн байх эсвэл хүлэмжийн хаалга нугастай байж болно.</p>		



	Хаалгыг 25мм х 25мм хэмжээтэй, 1,5 мм ханын зузаантай цайрдсан дөрвөлжин огтлолтой эсвэл 25 мм голчтой ган хоолойгоор хийнэ.		
8.	<b>Дагалдах багаж, сэлбэг:</b> Үйлдвэрлэгчийн стандартын дагуу дагалдах сэлбэг, хүлэмж угсрахад зайлшгүй шаардагдах багаж, температур болон агаарын харьцангуй чийг хэмжигчтэй, нар бууруулагч тортой байна.		
9.	Үнэ /төгрөг/		

*[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]*



## Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендэрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	“Зуны нийлэг хальсан хүлэмж Техникийн ерөнхий шаардлага” MNS 6636:2016 стандартын шаардлагыг хангасан өргөн 4 метр, урт 8 метр хэмжээтэй нийт 32 кв талбай бүхий иж бүрэн хүлэмж	1000-аас доошгүй	ширхэг	Монгол Улс Булган аймаг, Булган сум Хунс, хөдөө аж ахуйн газар	Гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн дотор	